



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/084/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: narangerelbatmunkh@audit.gov.mn Баян ташаагийн эх аудит захирал т.Хоролсүрэн Утас:99116028 Цахим хаяг: t.khorolsuren@yahoo.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/83
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 25 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй. Тайланд онд 209,288.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлийн санхүүжилт 208,288.3 мянган төгрөг авч, 163,937.5 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянцагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 5 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 91.4 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	806,000.00	1,304,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	806,000.00	1,304,000.00
354	Хангамжийн материал	806,000.00	1,304,000.00
35410	Бичиг хэргийн материал	438,000.00	936,000.00
35470	Бусад хангамжийн материал	368,000.00	368,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	110,993,340.44	111,202,194.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	110,993,340.44	111,202,194.69
392	Биет хөрөнгө	110,993,340.44	111,202,194.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	135,204,784.76	135,204,784.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,097,100.78)	(33,801,196.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,767,000.00	9,531,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,172,166.66)	(4,615,016.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,779,300.00	8,654,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,208,466.88)	(4,492,566.91)
39217	Ном	719,990.00	719,990.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	111,799,340.44	112,506,194.69
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	249,790.79	6,045,800.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	249,790.79	6,045,800.00
413	Өглөг	249,790.79	6,045,800.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	249,790.79	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		6,045,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	111,549,549.65	106,460,394.69
51	Засгийн газрын хувь оролцоо	111,549,549.65	106,460,394.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	112,776,090.00	112,776,090.00
51101	Өмч: - төрийн	112,776,090.00	112,776,090.00
512	Хуримтлагдсан үр дүн	(69,351,603.61)	(74,440,758.57)
51210	Өмнөх үеийн үр дүн	(69,351,603.61)	(69,351,603.61)
51220	Тайлант үеийн үр дүн		(5,089,154.96)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	68,125,063.26	68,125,063.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	111,799,340.44	112,506,194.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	178,324,900.00	209,288,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,377,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	3,377,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	174,947,900.00	209,288,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00

Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	173,947,900.00	208,288,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,947,900.00	208,288,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	182,240,844.37	214,377,454.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	182,240,844.37	214,377,454.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	169,853,636.13	168,906,689.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,184,058.21	128,004,129.19
210101	Үндсэн цалин	65,270,195.39	69,121,857.34
210102	Нэмэгдэл	44,448,319.82	43,989,410.96
210104	Урамшуулал	5,465,543.00	14,892,860.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,441,931.04	15,728,364.87
210201	Тэтгэврийн даатгал	9,800,704.95	10,994,768.51
210202	Тэтгэмжийн даатгал	1,087,073.58	1,139,887.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	711,390.55	702,460.05
210204	Ажилгүйдлийн даатгал	539,080.79	552,653.70
210205	Эрүүл мэндийн даатгал	2,303,681.17	2,338,595.20
2104	Хангамж, бараа материалын зардал	11,733,878.30	6,134,750.00
210401	Бичиг хэрэг	1,746,350.00	761,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,619,678.30	3,553,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	799,350.00	00.00
210404	Ном, хэвлэл	1,598,500.00	1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,970,000.00	20,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	
210604	Урсгал засвар	2,000,000.00	
2107	Томилолт, зочны зардал	1,913,000.00	1,360,000.00
210702	Дотоод албан томилолт	1,913,000.00	1,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,397,375.00	2,697,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,704,375.00	1,997,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		700,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	693,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,183,393.58	14,982,445.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,150,300.00	8,792,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,758,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,033,093.58	3,431,045.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,387,208.24	45,470,765.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	380,000.00	120,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	120,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,007,208.24	45,350,765.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,007,208.24	45,350,765.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(3,915,944.37)	(5,089,154.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(3,915,944.37)	(5,089,154.96)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	174,947,900.00	209,288,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	174,947,900.00	209,288,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	173,947,900.00	208,288,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,947,900.00	208,288,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	173,947,900.00	205,648,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	173,947,900.00	205,648,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	161,440,691.76	160,177,634.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,149,538.56	128,037,576.49
210101	Үндсэн цалин	65,270,195.30	69,155,304.64
210102	Нэмэгдэл	44,413,800.26	43,989,410.96
210104	Урамшуулал	5,465,543.00	14,892,860.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,216,599.90	15,944,708.36
210201	Тэтгэврийн даатгал	9,611,011.55	11,211,112.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,183,007.98	1,139,887.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	580,452.00	702,460.05
210204	Ажилгүйдлийн даатгал	715,557.00	552,653.70
210205	Эрүүл мэндийн даатгал	2,126,571.37	2,338,595.20
2104	Хангамж, бараа материалын зардал	8,389,528.30	5,542,250.00
210401	Бичиг хэрэг	992,000.00	871,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,999,678.30	2,851,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	799,350.00	
210404	Ном, хэвлэл	1,598,500.00	1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		20,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		278,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		278,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,393,000.00	1,360,000.00
210702	Дотоод албан томилолт	2,393,000.00	1,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,293,225.00	1,997,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,993,225.00	1,997,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,998,800.00	7,018,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,259,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,998,800.00	2,758,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,507,208.24	45,470,765.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	120,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		120,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,007,208.24	45,350,765.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,007,208.24	45,350,765.15

Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,000,000.00	3,639,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,000,000.00	3,639,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,000,000.00	3,639,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,000,000.00	3,639,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,000,000.00	3,639,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,000,000.00)	(3,639,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,776,090.00	68,125,063.26	(65,435,659.24)	115,465,494.02
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	112,776,090.00	68,125,063.26	(65,435,659.24)	115,465,494.02
C07	Тайлант үеийн үр дүн			(3,915,944.37)	-3,915,944.37 -
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,776,090.00	68,125,063.26	(69,351,603.61)	111,549,549.65
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	112,776,090.00	68,125,063.26	(69,351,603.61)	111,549,549.65
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	112,776,090.00	68,125,063.26	(69,351,603.61)	111,549,549.65
D08	Тайлант үеийн үр дүн			(5,089,154.96)	(5,089,154.96)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,776,090.00	68,125,063.26	(74,440,758.57)	106,460,394.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	208,288,300.00	208,288,300.00		100.0
310002	Орон нутгийн төсвөөс санхүүжих	208,288,300.00	208,288,300.00		100.0
	Орон нутгийн төсвөөс	208,288,300.00	208,288,300.00		100.0

Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	208,288,300.00	208,288,300.00		100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	208,288,300.00	208,288,300.00		100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	207,288,300.00	163,556,534.85	43,731,765.15	78.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,202,000.00	128,037,576.49	15,164,423.51	89.4
210101	Үндсэн цалин	72,519,600.00	69,155,304.64	3,364,295.36	95.4
210102	Нэмэгдэл	51,272,800.00	43,989,410.96	7,283,389.04	85.8
210104	Урамшуулал	19,409,600.00	14,892,860.89	4,516,739.11	76.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,900,300.00	15,944,708.36	1,955,591.64	89.1
210201	Тэтгэврийн даатгал	12,172,500.00	11,211,112.00	961,388.00	92.1
210202	Тэтгэмжийн даатгал	1,145,200.00	1,139,887.41	5,312.59	99.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,432,300.00	702,460.05	729,839.95	49.0
210204	Ажилгүйдлийн даатгал	286,100.00	552,653.70	(266,553.70)	193.2
210205	Эрүүл мэндийн даатгал	2,864,000.00	2,338,595.20	525,404.80	81.7
2104	Хангамж, бараа материалын зардал	10,500,000.00	5,542,250.00	4,957,750.00	52.8
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	871,000.00	629,000.00	58.1
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	2,851,250.00	2,148,750.00	57.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	-	1,000,000.00	-
210404	Ном, хэвлэл	2,000,000.00	1,800,000.00	200,000.00	90.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,000,000.00	20,000.00	980,000.00	2.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	3,917,900.00	82,100.00	97.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	3,917,900.00	82,100.00	97.9
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,360,000.00	640,000.00	68.0
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,360,000.00	640,000.00	68.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,686,000.00	1,736,000.00	1,950,000.00	54.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,086,000.00	1,736,000.00	1,350,000.00	64.7
210806	Мэдээллийн технологийн зардал	600,000.00		800,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,000,000.00	7,018,100.00	18,981,900.00	27.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,000,000.00	4,259,600.00	14,740,400.00	22.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	2,758,500.00	4,241,500.00	39.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	120,000.00	880,000.00	12.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	120,000.00	880,000.00	12.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	120,000.00	880,000.00	12.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн		44,611,765.15	(44,611,765.15)	

Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

	захирагчдад олгох татаас, санхүүжилт				
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		44,611,765.15	(44,611,765.15)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		(0.00)	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	(0.00)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3	3		100.0
620001	Удирдах ажилтан	2	2		100.0
620003	Гэрээт ажилтан	1	1		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	261,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	261,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	261,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	739,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	739,000.00
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	739,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 3,021.3 мянган төгрөгийн 1 зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 3,021.3 мянган төгрөгийн 9 хөрөнгийг дахин үнэлэх.	1	3,021.3					1	3,021.3
Дүн	1	3,021.3					1	3,021.3

-----oOo-----